

2024 ОНЫ 10 ДУГААР САР

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ОРШИЛ

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийг Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн. Монгол Улсын төсөв их хэмжээний алдагдалтай байгаа энэ үед төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оноос шилжин ирж буй төслүүдийн төсөвт өртөг ихээхэн нэмэгдэх хандлагатай байсан.

Энэхүү товч судалгаагаар “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж (2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралт)-ийн жагсаалтад багтсан шилжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж, анхаарах шаардлагатай асуудлуудыг гаргаж ирэхийг зорилгоо.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨРӨЛ

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт болох “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын төслийг авч үзэхэд 33 төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-ийн нийт 639 төсөл, арга хэмжээ тусгагдсан байна.


Үүний 108 буюу 16.9 хувь нь шинэ төсөл, арга хэмжээ бол 531 буюу 83.1 хувь нь шилжих арга хэмжээ байна. Төрлийн хувьд барилга байгууламж 555, тоног төхөөрөмж 53, их засвар 22, техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) 9 байна (Зураг 1).

Төсөл, арга хэмжээний төрлийг шинэ болон шилжих төслүүдээр авч үзвэл дараах байдалтай байна (Зураг 2).

Зураг 1. Монгол Улсын төсвөөс 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн төрөл



Зураг 2. Монгол Улсын төсвөөс 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын шинэ болон шилжих төслүүдийн тоо (төрлөөр)



2025 онд шилжиж буй нийт төсөл, арга хэмжээний 96.2 хувийг барилга байгууламж, 2.4 хувийг тоног төхөөрөмж, 1.1 хувийг их засвар, 0.2 хувийг ТЭЗҮ тус тус эзэлжээ.

Өмнөх оноос шилжиж буй барилга байгууламжийн тоогоор Боловсролын сайд,

Зам, тээврийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд тэргүүлж байна (Хүснэгт 1). Эдгээр гурван ТЕЗ-ийн шилжих барилга байгууламж нийт шилжиж буй барилга байгууламжийн 64 хувийг эзэлж байна.


Хүснэгт 1. Багцдаа хамгийн олон шилжих барилга байгууламж бүхий төсвийн ерөнхийлөн захирагч

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний тоо (нийт шилжиж буй барилга байгууламжид эзлэх хувь)
Боловсролын сайд	190 (37.2%)
Зам, тээврийн сайд	87 (17.0%)
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	50 (9.8%)
Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	46 (9.0%)
Эрүүл мэндийн сайд	31 (6.1%)

Өмнөх онуудаас 2025 онд шилжиж буй 531 төсөл, арга хэмжээний эхэлсэн оныг авч үзвэл 2018 ба түүнээс өмнө эхэлсэн 15 төсөл байна

(Зураг 3). 2024 онд эхэлсэн 366 төслийг 2025 онд санхүүжүүлэхээр байна.

Зураг 3. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын шилжих төслийн тоо (эхэлсэн оноор)



2025 онд санхүүжилт олгох хамгийн эрт эхэлсэн төсөл, арга хэмжээг авч үзвэл 2011 онд эхэлсэн 2 төсөл, 2012 онд эхэлсэн 1 төсөл, 2013 онд эхэлсэн 2 төсөл тус тус байна. Тэдгээрийг дурдвал:

2011 онд эхэлсэн төсөл, арга хэмжээ, ТЕЗ:

1. “Төв халх” дуулалт жүжгийн театр (Дундговь, Сайнцагаан сум)-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
2. Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд

2012 онд эхэлсэн төсөл, арга хэмжээ:

1. Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороо)-Эдийн засаг, хөгжлийн сайд

2013 онд эхэлсэн төсөл, арга хэмжээ

1. Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц (Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
2. Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр (Улаанбаатар, Хан-Уул дүүрэг)-Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Төсөл, арга хэмжээ эхэлсэн оны төсөвт өртөг ба 2025 оны төсөвт өртгийг 2018 он ба түүнээс хойш эхэлсэн төсөл, арга хэмжээний хувьд доор харьцуулж үзлээ (Хүснэгт 2).


Хүснэгт 2. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд туссан 2018–2024 онд эхэлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийн төсөвт өртгийн өөрчлөлт

Төсөвт өртгийн өөрчлөлтийн хувь	Төсөл, арга хэмжээний тоо, оноор						
	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Төсөвт өртөг буурсан	0	0	1	3	15	1	244
Төсөвт өртөг өөрчлөгдөөгүй	1	2	0	0	1	1	115
50 хүртэл хувиар өссөн	1	5	3	6	36	0	7
50 хувиас-2 дахин хүртэл дүнгээр өссөн	1	4	7	6	22	0	0
2 дахин ба түүнээс их дүнгээр өссөн	4	6	7	10	14	0	0
Нийт	7	17	18	25	88	2	366

2018 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Сургуулийн барилга, 250 суудал (Орхон, Баян-Өндөр сум, Рашаант баг)-Боловсролын сайд (төсөвт өртөг 4 дахин өсөж, 1 тэрбум төгрөгөөс 4 тэрбум төгрөг болсон)
2. Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 71 дүгээр сургууль)-Боловсролын сайд (төсөвт өртөг 2.7 дахин нэмэгдэж, 1.5 тэрбум төгрөгөөс 4.1 тэрбум төгрөг болсон)
3. Цэцэрлэгийн барилга, 100 ор (Говь-Алтай, Халиун сум)-Боловсролын сайд (төсөвт өртөг 2.2 дахин өсөж, 900 сая төгрөгөөс 2 тэрбум төгрөг болсон).

Зураг 4. 2018–2024 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн зарим төсөл, арга хэмжээ



2019 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Спорт заалны барилга (Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон)-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (төсөвт өртөг 4.7 дахин өсөж, 250 сая төгрөгөөс 1.2 тэрбум төгрөг болсон)
2. Сургуулийн барилга, 960 суудал (Хөвсгөл, Тариалан сум)-Боловсролын сайд (төсөвт өртөг 2.8 дахин нэмэгдэж, 4 тэрбум төгрөгөөс 11.2 тэрбум төгрөг болсон)
3. Сургуулийн барилга, 320 суудал (Баянхонгор, Баянцагаан сум)-Боловсролын сайд (төсөвт өртөг 2.8 дахин өсөж, 3.4 тэрбум төгрөгөөс 9.5 тэрбум төгрөг болсон).

2020 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Дуу бүжгийн "Боржигин" чуулгын барилга (Говьсүмбэр)-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (төсөвт өртөг 3.6 дахин өсөж, 3.5 тэрбум төгрөгөөс 12.4 тэрбум төгрөг болсон)
2. Соёлын төвийн барилга, 200 суудал (Хөвсгөл, Ренчинлхүмбэ сум)-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд (төсөвт өртөг 3.3 дахин нэмэгдэж, 1.4 тэрбум төгрөгөөс 4.6 тэрбум төгрөг болсон)
3. Сургуулийн барилга, 160 суудал (Баянхонгор, Заг сум)-Боловсролын сайд (төсөвт өртөг 2.9 дахин өсөж, 1.5 тэрбум төгрөгөөс 4.5 тэрбум төгрөг болсон).

2021 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Инженерийн шугам сүлжээ бүхий гэр хорооллын төсөл (Хөвсгөл, Мөрөн сум)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (төсөвт өртөг 7.3 дахин өсөж, 2.3 тэрбум төгрөгөөс 16.9 тэрбум төгрөг болсон)
2. Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга (Баян-Өлгий, Өлгий сум)-Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд (төсөвт өртөг 3.5 дахин нэмэгдэж, 1.9 тэрбум төгрөгөөс 6.8 тэрбум төгрөг болсон)
3. Музей, номын сангийн цогцолбор (Дархан-Уул, Дархан сум)-Соёл, спорт, аялал

жуулчлал, залуучуудын сайд (төсөвт өртөг 3.1 дахин өсөж, 5 тэрбум төгрөгөөс 15.6 тэрбум төгрөг болсон).

2022 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цахилгаан хангамж (Ховд, Дарви сум)-Эрчим хүчний сайд (төсөвт өртөг 4.7 дахин өсөж, 5.5 тэрбум төгрөгөөс 25.7 тэрбум төгрөг болсон)
2. Орон сууцжуулах төслийн дэд бүтэц (Баянхонгор, Баацагаан сум)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (төсөвт өртөг 4.2 дахин нэмэгдэж, 2.3 тэрбум төгрөгөөс 9.7 тэрбум төгрөг болсон)
3. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт (Говь-Алтай, Есөнбулаг сум, Харзат баг)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (төсөвт өртөг 3.6 дахин өсөж, 1.2 тэрбум төгрөгөөс 4.3 тэрбум төгрөг болсон)
4. Гэр хорооллын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил (Хөвсгөл, Мөрөн сум)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (төсөвт өртөг 3.2 дахин нэмэгдэж, 7 тэрбум төгрөгөөс 22.7 тэрбум төгрөг болсон)
5. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийх замаар инженерийн нэгдсэн шугам сүлжээний холболт (Говь-Алтай, Есөнбулаг сум, Индэрт баг)-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (төсөвт өртөг 3.2 дахин өсөж, 946 сая төгрөгөөс 3 тэрбум төгрөг болсон).

2023 онд эхэлсэн төслүүд

2023 он оноос шилжиж байгаа 2 төсөл, арга хэмжээний нэгийнх нь төсөвт өртөг буурчээ. Тухайлбал, Төв аймагт байршилтай "Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц" барилга байгууламжийн төсөвт өртөг 2023 онд батлагдахдаа 138.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд төсөвт өртөг нь 2.3 тэрбум төгрөгөөр буурч, 135.6 тэрбум төгрөгөөр батлагдсан байна. Харин Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй түгжрэлийг бууруулах,

хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгах гэсэн 2023 онд эхэлсэн, 2026 онд дуусах хуваарьтай барилга байгууламжийн төслийн төсөвт өртөг 45 тэрбум төгрөг хэвээр байсан.

2024 онд эхэлсэн төслүүд

2024 онд эхэлсэн 366 төсөл, арга хэмжээний хувьд төсөвт өртөг нь багассан 244 төсөл, арга хэмжээ байгаа бол төсөвт өртөг нь өөрчлөгдөөгүй 115, 50 хүртэл хувиар өссөн ердөө 7 төсөл, арга хэмжээ байна.


2024 онд эхэлсэн бөгөөд төсөвт өртөг нь хамгийн их нэмэгдсэн төсөл, арга хэмжээ:

1. Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц (Улсын хэмжээнд)-Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд (төсөвт өртөг нь 1.2 дахин өсөж, 20 тэрбум төгрөгөөс 24.4 тэрбум төгрөг болсон)
2. Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)-Батлан хамгаалахын сайд (төсөвт өртөг нь 40.6 тэрбум төгрөгөөс 45.4 тэрбум болж, 1.1 дахин нэмэгдсэн).

2025 онд шилжиж байгаа 531 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2024 онд батлагдаж байсан төсөвт өртөгтэй нь харьцуулахад тун сонирхолтой үр дүн гарсан. Тодруулбал, 2024 онд дээрх 531 төсөл, арга хэмжээний батлагдсан төсөвт өртөг нийт 7.5 их наяд төгрөг

байсан бол 2025 онд батлагдсан нийт төсөвт өртөг нь 7.4 их наяд төгрөг болж багассан байна. Төсөвт өртөг нь нэмэгдсэн 36 төсөл, арга хэмжээ байгаа бол буурсан 279 (270 нь барилга байгууламж, 8 нь тоног төхөөрөмж, 1 нь ТЭЗҮ), өөрчлөгдөөгүй 216 төсөл, арга хэмжээ байна. Төсөвт өртөг ийнхүү буурсан шалтгаан нь 2024 онд эхэлсэн олон төсөл, арга хэмжээний тендер зарлагдан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, санал болгосон дүнгээр нь гэрээ байгуулсантай холбоотой юм. Тухайлбал, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Ахмадын өргөөний барилгын төсөвт өртөг 2024 онд 2.66 тэрбум байсан бөгөөд “Мөнхийн үргэлжлэл” ХХК 2024 оны 4 дүгээр сард 2.59 тэрбум төгрөгөөр тендерт ялалт байгуулж, гэрээ байгуулах эрхтэй болсон байна.¹ Тиймээс 2025 оны төсвийн төсөлд уг барилгын төсөвт өртгийг 2.59 тэрбум гэж тусгасан байх жишээтэй. Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны барилга,² Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 2 дугаар цэцэрлэгийн барилга,³ Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил,⁴ Дархан-Уул аймгийн Дархан сумын 31 дүгээр хорооллын дулаан хангамжийн ажил⁵ зэргийг мөн авч үзэхэд шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан дүн нь 2024 оны төсөвт өртгөөс бага байсан тул 2025 оны төсвийн төсөлд төсөвт өртгийг нь гэрээний дүнгээр буюу багасгаж тусгасан байна.

Зураг 5. 2025 онд шилжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2024 онд батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулсан харьцуулалт



¹ <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1710902986664>
² <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1715157293351>
³ <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1718598385128>
⁴ <https://user.tender.gov.mn/mn/result/detail/1713407129788>
⁵ <https://www.tender.gov.mn/mn/result/detail/1713407334428>

Хүснэгт 3. 2024 онд батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулахад 2025 онд төсөвт өртөг нь мэдэгдэхүйц буурсан төсөл, арга хэмжээ

Төсөл, арга хэмжээний нэр	Төрөл	Эхлэх/дуусах он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	2025 оны төсөвт өртөг	2025/2024 оны өөрчлөлт
Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт (Улсын хэмжээнд)	Тоног төхөөрөмж	2019/2025	32.2 тэрбум	114.1 тэрбум	84.1 тэрбум	30 тэрбум төгрөгөөр буурсан
Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах (Баянхонгор)	Барилга байгууламж	2021/2025	12 тэрбум	15.3 тэрбум	9.7 тэрбум	5.6 тэрбум төгрөгөөр багассан
Хэрлэн голын төмөрбетон гүүр, 265 у/м, хатуу хучилттай авто зам, 14.2 км (Хэнтий, Хэрлэн сум)	Барилга байгууламж	2024/2026	54.5 тэрбум	54.5 тэрбум	49.9 тэрбум	4.6 тэрбум төгрөгөөр багассан
Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл (Улсын хэмжээнд)	Барилга байгууламж	2022/2025	45.9 тэрбум	61.8 тэрбум	57.9 тэрбум	3.9 тэрбум төгрөгөөр багассан
Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дөрөвдүгээр хэсэг, 23.13 км (Баян-Өлгий)	Барилга байгууламж	2024/2026	46.9 тэрбум	46.9 тэрбум	43.1 тэрбум	3.8 тэрбум төгрөгөөр багассан
Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц (Улсын хэмжээнд)	Барилга байгууламж	2022/2025	100.0 тэрбум	109.9 тэрбум	106.9 тэрбум	3.0 тэрбум төгрөгөөр багассан
Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км (Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум)	Барилга байгууламж	2022/2026	115.9 тэрбум	185.4 тэрбум	182.6 тэрбум	2.8 тэрбум төгрөгөөр буурсан
“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл (Төв)	Барилга байгууламж	2023/2026	138.4 тэрбум	138.4 тэрбум	135.6 тэрбум	2.8 тэрбум төгрөгөөр буурсан
Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум, 3, 4, 5 дугаар баг)	Барилга байгууламж	2024/2026	62.8 тэрбум	62.8 тэрбум	60.3 тэрбум	2.5 тэрбум төгрөгөөр багассан
Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал (Төв, Зуунмод сум, 5 дугаар сургууль)	Барилга байгууламж	2024/2026	9.5 тэрбум	9.5 тэрбум	7.2 тэрбум	2.3 тэрбум төгрөгөөр буурсан

Хүснэгт 4. 2024 онд батлагдсан төсөвт өртөгтэй нь харьцуулахад 2025 онд төсөвт өртөг нь мэдэгдэхүйц нэмэгдсэн төсөл, арга хэмжээ

Төсөл, арга хэмжээний нэр	Төрөл	Эхлэх/дуусах он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	2025 оны төсөвт өртөг	2025/2024 оны өөрчлөлт
Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж (Улсын хэмжээнд)	Тоног төхөөрөмж	2024/2025	40.6 тэрбум	40.6 тэрбум	45.4 тэрбум	4.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн
Хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц (Улсын хэмжээнд)	Барилга байгууламж	2024/2025	20 тэрбум	20 тэрбум	24.4 тэрбум	4.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг үзэхэд ижил хүчин чадалтай төсөл, арга хэмжээний төсөвт өртөг анхаарал татахаар хэлбэлзэлтэй байсангүй. Тухайлбал, иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн байр Архангай аймгийн Булган сум, Цахир сум, Говь-Алтай аймгийн Баян-Уул сум, Тайшир сум гэсэн дөрвөн байршилд бүгд ойролцоо, 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй байв. Завхан аймгийн Улиастай сумын цагдаагийн газрын барилга 5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй

байгаа бол Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 4.5 тэрбум төгрөг байсан. 100 ортой дотуур байрны барилгын төсөвт өртөг Архангай аймгийн Төвшрүүлэх суманд 2.8 тэрбум төгрөг, Баян-Өлгий аймгийн Баяннуур суманд 3 тэрбум, Говь-Алтай аймгийн Дэлгэр суманд 2.7 тэрбум төгрөг байгаа юм. Эдгээр төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь 2024 онд батлагдсан төсөл, арга хэмжээ байгаа бөгөөд төсөвт өртөг нь 2025 онд 2024 онд батлагдаж байсан төсөвт өртгөөсөө нэмэгдээгүй, харин ч багассан байна.

ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГАА

Олон жил үргэлжилсэн бөгөөд төсөвт өртөг нь өөрчлөгдсөн зарим төслийн хэрэгжилт удааширсан шалтгааны талаар судалж үзлээ. Төслийн хэрэгжилт удаашрахад нөлөөлж буй хэд хэдэн шалтгаан байгаагийн дотор голчлон

тухайн онд санхүүжилт батлагддаггүй болон батлагдсан санхүүжилтийг цаг тухайд нь олгоогүйгээс үүдэлтэй байна. Энэ нь доорх төслүүдийн хэрэгжилтээс харагдаж байна. Үүнд:

Дундговь аймгийн Сайнцагаан суманд байршилтай “Төв халх” дуулалт жүжгийн театрын барилга

2012 онд Дундговь аймагт баригдаж эхэлсэн “Төв Халх” дуулалт жүжгийн театрын барилга нь эхний 2 жилийг эс тооцвол 2013-2018 онд улсын төсөвт тусгагдаагүйн улмаас санхүүжилтгүй болж, олон жил “царцсан” тул барилгын ажлын эхэн үед хийгдсэн барилгын суурь, шалны бетон арматур зэрэг нь элэгдэж, улмаар дахин хийх шаардлагатай болжээ. Энэ нь олон

жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэх шалтгаануудын нэг мөн бөгөөд төсвийн хөрөнгийг үрэлгэн, үр дүн муутай зарцуулж байгаагийн нэг тод жишээ юм. Төсөвт өртөг нь 2021 онд 4 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдсэн уг театрын барилга ажлыг 2025 онд дуусгахаар энэ оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгажээ.

Хүснэгт 5. Дундговь аймгийн "Төв Халх" дуулалт жүжгийн театрын барилгын төслийн санхүүжилт, хэрэгжилт

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая. төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Эхлэх/дуусах он
2011	6,800.0	440.0	2011/2013
2012	6,800.0	3,300.0	2011/2014
2013	-	Тусгагдаагүй	-
2014	-	Тусгагдаагүй	-
2015	-	Тусгагдаагүй	-
2016	-	Тусгагдаагүй	-
2017	-	Тусгагдаагүй	-
2018	-	Тусгагдаагүй	-
2019	6,800.0	2,000.0	2011/2020
2020	6,800.0	50.0	2011/2021
2021	10,543.7	1,710.0	2011/2022
2022	10,543.7	200.0	2011/2023
2023	10,543.7	671.7	2011/2024
2024	10,543.7	2,000.0	2011/2025
2025	10,543.7	5,832.0	2011/2025

Эх сурвалж: Монгол Улсын 2011-2025 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний санхүүжилтэд төсөвт өртгийн ердөө 6.5 хувьтай тэнцэх л хөрөнгийг тусгаж байжээ. Төслийн санхүүжилт 2013-2018 оны төсөвт тусгагдаагүй бөгөөд 2019 оноос эхлэн санхүүжилт нь төсөвт дахин батлагдаж

эхэлсэн. Өнгөрсөн хугацааны батлагдсан санхүүжих дүн нийтдээ 16,203.7 сая төгрөг буюу 2025 оны төсөвт өртгөөс даруй 5,660 сая төгрөгөөр давж гараад байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Говийн ирээдүй цогцолбор" сургуулийн барилга

Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн 960 суудалтай шинэ барилгын суурь тавих үйл ажиллагаа 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр болсон. Сургуулийн хуучин барилгыг буулгаж, суурин дээр нь шинэ барилгын шав тавьсан бөгөөд

"Си Эйч Ди Жи" ХХК 2021-2022 онд хийж дуусгахаар төлөвлөсөн. Гэвч 2024 оны 9 дүгээр сар гэхэд барилгын ажил дуусаагүй, сурагчид сургуулийнхаа өөр нэг хуучин байранд хичээллэж байна.

Хүснэгт 6. Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн барилгын төслийн санхүүжилт, хэрэгжилт

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая. төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Эхлэх/дуусах он
2021	5,496.4	2,748.2	2021/2022
2022	5,496.4	2,748.2	2021/2022
2023	5,987.9	491.5	2021/2023
2024	14,726.6	4,454.3	2021/2025
2025	14,274.3	4,369.4	2021/2025

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний 2 жилд санхүүжилтэд төсөвт өртгийн тус бүр 50 хувьтай тэнцэх хөрөнгийг тусгаж 2022 онд багтаан дуусгахаар төсөвлөж төсвийн тухай хуулийг баталсан ч бодит байдал дээр гүйцэтгэгч компанид санхүүжилт олгогдоогүй. Цалин хөлс, барилгын түүхий

эдийн зардлын өсөлтөөс шалтгаалан 2024 онд тус барилгын төсөвт өртөг анхны төсөвт өртгөөс даруй 2.7 дахин нэмэгджээ. 2024 оны 8 сарын байдлаар барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байсан.

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга

Баян-Өлгий аймгийн Өлгий суманд Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилгыг 2021 оноос орон нутгийн "Монстрой-Эра" ХХК барьж эхэлсэн. Тус хөгжлийн төв нь 3000 м²

талбайтай, дотроо хүүхэд, залуучуудад зориулсан төрөл бүрийн сургалтын танхим, усан бассейн, урлаг, спортын заал, номын сан, кофе шоп, тоглоомын талбайтай байх аж.

Хүснэгт 7. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилгын төслийн санхүүжилт, хэрэгжилт

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая. төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Эхлэх/дуусах он
2021	1,930.0	422.4	2021/2022
2022	1,930.0	1,507.0	2021/2022
2023	6,803.9	500.0	2021/2024
2024	6,803.9	4,393.6	2021/2024
2025	6,803.9	1,000.1	2021/2025

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний санхүүжилтэд төсөвт өртгийн 21.9 хувьтай тэнцэх хөрөнгийг тусгаж байжээ. Барилгын төсөвт өртөг 2023 онд 3.5 дахин нэмэгдсэн бөгөөд энэ нь тухайн төсөл,

арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд дуусгаж чадахгүй байх нь ямар хор уршигтай вэ гэдгийг харуулж байгаа өөр нэг жишээ юм.

Дархан-Уул аймгийн Дархан сумын музей, номын сангийн цогцолбор

Дархан-Уул аймгийн Дархан сумын "Миний Монгол" цэцэрлэгт хүрээлэнд Музей, номын сангийн цогцолборын барилга 2021 оноос

баригдаж эхэлсэн. Тус барилга нь зоорины давхартайгаа нийлээд дөрвөн давхар, нийт 5900 м.кв талбай бүхий цогцолбор юм.

Хүснэгт 8. Дархан-Уул аймгийн Дархан сумын Музей, номын сангийн цогцолборын барилгын төслийн санхүүжилт, хэрэгжилт

Төсвийн жил	Төсөвт өртөг, сая. төгрөг	Санхүүжих дүн, сая төгрөг	Эхлэх/дуусах он
2021	5,000.0	1,000.0	2021/2022
2022	14,533.0	2,400.0	2021/2023
2023	15,600.5	5,920.0	2021/2024
2024	15,600.5	6,280.5	2021/2024
2025	15,600.5	1,143.0	2021/2025

Эх сурвалж: Монгол Улсын 2021-2025 оны төсвийн тухай хууль

Энэ төслийн эхний санхүүжилтэд төсөвт өртгийн 20 хувьтай тэнцэх хөрөнгийг тусгаж байжээ. 4 давхар барилгын ажилд төсөвт өртгийн 20 хувийн санхүүжилтийг олгохоор баталсан хэр дараа жил нь ашиглалтад оруулна гэж төлөвлөх нь анхнаасаа бодитой биш байсныг өнөө хэр дуусаагүй барилга харуулж байна. Түүнчлэн төсөвт өртгийг эхнээсээ хэт багаар тооцжээ. Гүйцэтгэгч компани ажлаа 2021 оны 8 сарын 27-нд буюу тухайн ондоо нэлээд орой эхлүүлсэн бөгөөд зураг төслөөс суурийн өндрийн түвшин зөрсөн учраас алдааг засварлуулах шаардлага гарсан. Энэ нь мөн барилгын ажлын гүйцэтгэл

удаашрахад нөлөөлжээ (Эх сурвалж: <https://oronzai.mn/n/fvL3KvxApCJ96xJ9hBSg>).

2022 онд барилгын төсөвт өртөг 14.5 тэрбум төгрөг болж нэмэгдэхэд дахин тендер зарласан ч зөвхөн нэг л оролцогч буюу эхний гүйцэтгэгч компани болох “Вокон Констракшн” ХХК санал ирүүлсэн ч шаардлага хангаагүй тул тендер амжилтгүй болсон. 2023 онд цогцолборын интерьерийн зураг төслийн тендер шалгаруулалт зарлагдахад “Эрхэс Констракшн” ХХК шалгарсан байна. “Вокон Констракшн” ХХК 2023 оноос барилгын ажлыг дахин үргэлжлүүлжээ.

ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дурдсанаар 531 төсөл, арга хэмжээ өмнөх онуудаас шилжиж байгаа бөгөөд энэ нь нийт төсөл, арга хэмжээний 83.1 хувийг эзэлж байна.
2. 2025 онд шилжиж буй нийт төсөл, арга хэмжээний 96.2 хувийг барилга байгууламж эзэлж байна.
3. Хамгийн олон шилжих барилга байгууламж Боловсролын сайд, Зам тээрийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад байна.
4. Төсөвт өртөг нь 2 ба түүнээс их дахин нэмэгдсэн төсөл, арга хэмжээний тоо жилээс жилд өсөх хандлагатай байна. Тодруулбал, 2018 оны төсөвт 4, 2019 онд 6, 2020 онд 18, 2021 онд 25, 2022 онд 14 төсөл, арга хэмжээ тус тус байсан.
5. 2025 оны төсвийн төсөлд шилжих төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэлээд бууруулан тусгасан байна. Тухайлбал, 2022 оноос шилжиж байгаа 15 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 2025 оны төсвийн төсөлд бууруулан төсөвлөсөн бол 2024 оноос шилжиж байгаа 244 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг мөн багасган тусгажээ.
6. 2025 оны төсвийн төсөлд 2011 оноос 2 төсөл, арга хэмжээ шилжиж байгаа нь хамгийн эрт батлагдсан төсөл, арга хэмжээ болж байна.
7. Төслийн хэрэгжилт удаашрахад нөлөөлж буй хэд хэдэн шалтгаан байгаагийн дотор голчлон тухайн онд санхүүжилт батлагддаггүй болон батлагдсан санхүүжилтийг цаг тухайд нь олгоогүйгээс үүдэлтэй байна.
8. 2025 онд шилжих 531 төсөл, арга хэмжээний 287 (54 хувь) нь 2025 онд, 238 (44.8 хувь) нь 2026 онд, 6 (1.1 хувь) нь 2027 онд дуусах хуваарьтай байна.
9. 2025 оны төсвийн төсөлд тусгагдсан шилжих төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг төдийлөн нэмэгдээгүй, эхэлсэн оныг өөрчилсөн зөрчилгүй байна. Үүнийг цаашид сайн жишиг болгох хэрэгтэй.
10. Тухайн оны төсвийн тухай хуулийн Хавсралт 2 буюу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, байгууламжийн жагсаалтад төсөл тус бүрийн тухайн он хүртэл хугацаанд авсан санхүүжилтийн нийт дүн буюу гүйцэтгэлийн дүнг нэмж тусгадаг болох.

ХАВСРАЛТ

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН ТӨСӨВТ ӨРТӨГ НЬ
НЭМЭГДСЭН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

(сая төгрөг)

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг		Анхны төсөвт өртгөөс өөрчлөгдсөн хувь	2025 онд санхүүжих дүн
						Анхны	Сүүлийн		
	IV	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД							
	IV.2	Шинжлэх ухаан							
	IV.2.1	I. Барилга байгууламж							
1	IV.2.1.1	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор /УБ/	УТ2001500725	2020	2026	94,000.0	154,491.7	64.4%	30,444.7
2	IV.2.1.2	Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга / УБ, БЗД, 13 дугаар хороо/	УТ2101501043	2012	2025	4,000.0	5,278.8	32.0%	1,000.2
	V	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД							
	V.1	Онцгой байдлын ерөнхий газар							
	V.1.1	I. Барилга байгууламж							
3	V.1.1.2	Онцгой байдлын ерөнхий газрын мэргэжлийн сургалтын төвийн барилга /УБ/	УТ2100900057	2022	2025	4,400.0	12,461.2	163.2%	5,118.5
	V.2	Алтанбулаг чөлөөт бүс							
	V.2.1	I. Барилга байгууламж							
	VI	МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА							
	VI.1	I. Барилга байгууламж							
4	VI.1.16	Удирдлагын академийн кампус, өргөтгөлийн барилга /УБ, ХУД/	УТ2001000070	2021	2025	18,827.2	20,723.0	10.1%	4,002.0
	X	САНГИЙН САЙД							
	X.1	Гаалийн ерөнхий газар							
	X.1.3	III. Тоног төхөөрөмж							
5	X.1.3.3	Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт /Улсын хэмжээнд/	УТ2001100127	2019	2025	32,195.2	114,143.9	161.1%	16,400.0

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг			Анхны төсөвт өртгөөс өөрчлөгдсөн хувь	2025 онд санхүүжих дүн
						Анхны	Сүүлийн	2025 онд		
	XI	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД								
	XI.1	Хил хамгаалах ерөнхий газар								
	XI.1.3	III. Тоног төхөөрөмж								
6	XI.1.3.3	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт /Улсын хэмжээнд/	УТ2101201136	2021	2025	17,325.4	18,325.4	18,325.4	5.8%	4,274.4
	XII	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД								
	XII.2	Зэвсэгт хүчний Жанжин штаб								
	XII.2.3	III. Тоног төхөөрөмж								
7	XII.2.3.1	Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	УТ2401400221	2024	2025	40,576.3	40,576.3	45,358.7	11.8%	9,593.4
	XIV	БОЛОВСРОЛЫН САЙД								
	XIV.1	Боловсрол								
	XIV.1.1	I. Барилга байгууламж								
8	XIV.1.1.1 0	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, БНД, 3 дугаар хороо/	УТ2101500839	2022	2025	3,500.0	6,824.4	6,730.8	92.3%	3,230.8
9	XIV.1.1.1 1	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, Налайх дүүрэг, 4 дүгээр хороо/	УТ2101500875	2022	2025	4,552.7	5,039.6	5,039.7	10.7%	684.6
10	XIV.1.1.1 2	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /УБ, ХУД, 8 дугаар хороо/	УТ2101500873	2022	2025	4,552.7	5,838.0	5,798.3	27.4%	5,698.3
11	XIV.1.1.1 3	Дотуур байрны барилга буулгаж, шинээр барих, 160 ор /Говь-Алтай, Баян-Уул сум, 1 дүгээр баг/	УТ2101500208	2022	2025	3,515.0	5,694.4	5,694.4	62.0%	2,465.9
12	XIV.1.1.1 4	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Даланзадгад сум/	УТ2101500524	2022	2025	2,274.2	4,559.1	4,559.1	100.5%	2,185.8
13	XIV.1.1.1 5	Дотуур байрны барилга, 160 ор /Дорнод, Баян-Уул сум/	УТ2101500351	2022	2025	2,916.2	4,795.3	4,795.3	64.4%	1,903.0
14	XIV.1.1.1 6	Дотуур байрны барилга, 160 ор /Хөвсгөл, Төмөрбулаг сум/	УТ2101501264	2022	2025	3,229.9	5,173.5	5,173.5	60.2%	1,946.1
15	XIV.1.1.1 8	Насан туршийн боловсролын төвийн барилга /УБ, БЗД, 21, 27-р хороо/	УТ2101500127	2022	2025	2,500.0	3,184.3	3,184.3	27.4%	886.3

Д/д	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төслийн код	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг			Анхны төсөвт өртгөөс өөрчлөгдсөн хувь	2025 онд санхүүжих дүн
						Анхны	Сүүлийн	2025 онд		
